



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР БЭЛЭГ ДУРСГАЛЫН ЗҮЙЛ ХУДАЛДАН АВАХ,
ТОМИЛОЛТЫН НӨХӨН ОЛГОВОР, ТЭТГЭМЖ, УРАМШУУЛАЛ БОЛОН ТӨСӨЛ,
ХӨТӨЛБӨРИЙН ЗАРЛАГА ДАВХАРДАН ЗАРЦУУЛАГДСАНААС ТӨСВИЙН ҮР
АШИГТ БАЙДАЛ, ЗАРДЛЫН ХЭМНЭЛТЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БАЙНА.

“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”

АУДИТЫН КОД: СБА-2025/21-16-ШТА-НА

Баруун-Урт 2025 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
Аудитын менежер М.Нарантуяа

Ахлах аудитор С.Ариунбаяр

Утас: 70512123, Цахим хаяг: Ariunbayars@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунзул

Цахим хаяг: Arzulb@audit.gov.mn

Аудитор: А.Мөнхцэцэг

Цахим хаяг: Munkhtsesega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/49

Баруун-Урт сум

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн нийцлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитын шалгалтаар илрүүлсэн зөрчилтэй холбоотой төлбөрийн акт, зөрчил арилгуулах албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар, аймаг, сумын Засаг дарга, ЗДТГ, ИТХ-д хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (С.Ариунбаяр)-д үүрэг болгосугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 06 дугаар сарын 12, биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймаг, сумын Засаг дарга, Засаг даргын тамгын газрын дарга нарт хариуцуулсугай.

4.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (С.Ариунбаяр), аудитор (А.Мөнхцэцэг), аудитор (Б.Ариунзул) нарт үүрэг болгосугай.

5.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ДАВАА

D:\Бичиг хэрэг\2025\Тушаал\А тушаал 2025.docx

2225010176

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёг.....	4
Дүрслэлийн товъёг.....	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	5
1.1 Суудлын авто тээврийн хэрэгсэл ашиглах албан тушаалтан Засгийн газрын тогтоолоор баталсан хэм хэмжээг дагаж мөрдөөгүй, хуулиар зөвшөөрөөгүй арга хэмжээнд төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан байна.....	6
1.2 Төсвийн хөрөнгийг хууль, журмын хүрээнд зарцуулах шаардлага хангагдаагүй, зарцуулалтын ил тод байдал, санхүүгийн сахилга хариуцлага сул байгаагаас зөрчил, давхардал, зохицуулалтын зөрүү үүссэн байна.....	14
Бүлэг 2. Төсвийн байгууллагууд цахим дэлгүүр ашиглан худалдан авалт хийх үйл ажиллагаа хангалтгүй, орон нутгийн чиг үүрэг хамаарах төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн байна.....	18
2.1 Орон нутгийн чиг үүрэгт хамаарах төсөл арга хэмжээг УТХО-аар гүйцэтгүүлж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцэхгүй байна.....	18
2.2 ОНХС-ийн төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг цахим системд байршуулж хэвшсэн ч төсвийн байгууллагуудын нийт худалдан авсан үндсэн хөрөнгийн зөвхөн 19.0 хувийг цахим дэлгүүрээр дамжуулан авсан байна.....	19
Бүлэг 3. Төсвийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн зарцуулаагүйгээс 510.3 сая төгрөгийн хэмнэлтийг орон нутгийн хэмжээнд хийх боломжийг алдаж, үр ашиггүй зарцуулсан нь төсвийн төлөвлөлт, хяналтыг сайжруулах шаардлагатайг илтгэж байна.....	20
3.1 Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.....	20
3.2 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор төсвөөс санхүүгийн дэмжлэг олгож байна.....	21
3.3 Төсвийн байгууллагууд хөрөнгө зарцуулах тушаал шийдвэрийн шилэн дансны цахим системд мэдээлдэггүй нийтлэг зөрчил гаргаж байна.....	25
ДҮГНЭЛТ:.....	28
ЗӨВЛӨМЖ:.....	30
Үндэсний аудитын газраар уламжлуулах санал:.....	31

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Байгууллага
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХЯ	Батлан хамгаалах яам
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗГ	Монгол улсын засгийн газар
МУЗЗНДНТУТХ	Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
НА	Нийцлийн аудит
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”

СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СБА	Сүхбаатар аймаг
ҮАГ	Үндэсний аудитын газар
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТБОНӨХБАҮХАТ Х	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮТП	Үйлдвэр технологийн парк
ХЗДХС	Хууль зүй дотоод хэргийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШТА	Шууд тайлагналын аудит
ЭМБС	Эрүүл мэнд боловсрол сан

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Байр ашиглалтын зардлын судалгаа 2020-2024 он	14
2	Өр төлбөрийн харьцуулсан судалгаа 2020-2024 он	15
3	Цахим худалдан авах ажиллагааны судалгаа	16
4	GPS байршлын судалгаа	18
5	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт олгосон санхүүгийн дэмжлэгийн судалгаа	20
6	Шилэн дансны зөрчлийн судалгаа	22

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Шилэн дансны зөрчлийн судалгаа	21

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.10-т заасан бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны 12 дугаар сарын 25-ны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн хэрэгжүүлэв.
Аудитын зорилт	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв.
Аудитын хамарсан хүрээ	Аудитыг Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд, ТӨҮГ болон ОНӨҮГ-ын 2022-2024 оны санхүүгийн үйл ажиллагааг түүвэрт хамруулж холбогдох баримт материалын хүрээнд хийж гүйцэтгэв.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС 100, 400, 4000-4200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-4:2020, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, харьцуулах, түүвэрлэлт хийх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитын дэд төлөвлөгөөг 2025 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн дотор батлуулж, талбарын ажлыг ажлыг 03 дугаар сарын 17-ний өдрөөс 5 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 05 дугаар сарын 12-ны өдрийн дотор боловсруулж, үе шатны хяналтыг хийлгэн, Тэргүүлэх аудиторовын тушаалаар баталгаажуулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

БҮЛЭГ 1 Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах, томилолтын нөхөн олговор, тэтгэмж, урамшуулал болон төсөл, хөтөлбөрийн зарлага давхардан зарцуулагдсанаас төсвийн үр ашигт байдал, зардлын хэмнэлтэд сөргөөр нөлөөлж байна.

1.1 Суудлын авто тээврийн хэрэгсэл ашиглах албан тушаалтан Засгийн газрын тогтоолоор баталсан хэм хэмжээг дагаж мөрдөөгүй, хуулиар зөвшөөрөөгүй арга хэмжээнд төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан байна.

1.1.1 Аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн Б/49 захирамжаар нэг орлогчийг үүрэгт ажлаас чөлөөлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэхтэй холбоотой бөгөөд одоогоор аймаг, сумын Засаг дарга нэг орлогчтойгоор гүйцэтгэх засаглалын чиг үүргийг хэрэгжүүлж байна.

1.1.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны Б/03, 04 дүгээр захирамжаар дэд бүтэц, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан, улс төр, нийгмийн бодлого хариуцсан зөвлөхүүдийг чөлөөлсөн бөгөөд хуулийн хэрэгжилттэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны Б/60, 61 дүгээр захирамжаар эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал болон хөрөнгө оруулалт, дэд бүтэц хариуцсан зөвлөхүүдийг чөлөөлсөн байна.

1.1.3 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2022 оны Б/34 дүгээр тушаалаар дэд даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлсөн байна.

1.1.4 Засаг даргын орлогч, зөвлөх чиг үүрэг бүхий албан тушаалтан, дэд даргыг хуулийн хэрэгжилтийн хүрээнд үүрэгт ажлаас нь чөлөөлснөөр төсвийн жилд дунджаар 106.3 сая төгрөгийг хэмнэсэн тооцоолол гарч, төсвийн зарцуулалтыг хэмнэх, үр ашгийг сайжруулах боломжийг бий болгосон байна.

1.1.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2022 оны “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоол баталсан бөгөөд уг тогтоолоор суудлын авто машин ашиглах албан тушаалтны жагсаалтыг баталж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сумын Засаг даргад өдөр тутамдаа авто машин ашиглах эрх олгосон.

1.1.6 Гэтэл сумын ИТХ-ын ажлын алба (ихэнх сумын ИТХ авто машингүй) 2023 онд 70.8 сая, 2024 онд 84.7 сая төгрөгийг шатахууны зардалд зарцуулсан нь хууль, тогтоолын шаардлагад нийцэхгүй, эдгээр зардлын ихэнх нь хувийн эзэмшлийн авто машинд зарцуулсан нь төсвийн зохистой зарцуулалт, хэмнэлтийн шаардлагыг зөрчиж, төрийн санхүүгийн хариуцлагын тогтолцоонд сөргөөр нөлөөлж байна.

1.1.7 Аймгийн ИТХ-ын дарга, Засаг даргын өдөр тутмын үйл ажиллагаанд зарцуулсан шатахууныг Монгол Улсын Засгийн газрын 204 дүгээр тогтоолын 8¹ дугаар зүйлд заасантай уялдуулан тооцож үзэхэд дараах үзүүлэлт гарч байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын албан тушаалын авто тээврийн шатахууны зардлын хэмнэлт болон зарцуулалттай холбоотой мэдээллийг дараах байдлаар тооцож гаргасан. Тодруулбал, 2023-2024 онд нийт 31.2 сая төгрөгийн шатахуун

¹ албан тушаалын суудлын автомашин

зарцуулсан бөгөөд өдөр тутмын үйл ажиллагаанд зөвхөн ажлын өдөрт ногдох нормативаар тооцож, томилолтоор ажилласан хоногийг хасахаар ойролцоогоор 21.0 сая төгрөгийн шатахуун зарцуулах тооцоолол гарсан. Үүний үндсэн дээр, дээрх онуудад нийт 10.0 сая төгрөгийн шатахууны зардлыг хэтрүүлсэн бөгөөд шатахууны зардлыг хэмнэх боломжийг алдсан зураглал харагдаж байна.

- Аймгийн ИТХ-ын ажлын алба 2023 онд 43.5 сая төгрөг, 2024 онд 52.0 сая төгрөгийг шатах тослох материалын зардалд зарцуулсан байна. Түүний дундаж зардал нь жилдээ ойролцоогоор 47.75 сая төгрөг бөгөөд хот дотор явбал зохих нормативаар тооцоход ойролцоогоор 11.3 сая төгрөгийн шатахуун зарцуулах бөгөөд томилолтоор ажиллах үеийн шатахууны зардлыг нэмэхэд жилд нийтдээ 22.0-25.5 сая төгрөг зарцуулах тооцоолол гарч байна. Мөн эдгээр тооцоолол, баримтад үндэслэн үзвэл, байгууллагад шатахууны зардлыг нэг жилд дунджаар 24.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн бөгөөд хэмнэх боломж алдагдсан байна. Энэ нь хэмнэлтийн боломжийг ашиглах, зарцуулагдаж буй зардлыг зөв удирдах хэрэгцээ шаардлага байгааг илтгэж байна.

1.1.8 Авто тээврийн үндэсний төвд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 359 авто тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа бөгөөд дээрх тээврийн хэрэгслүүдэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4² хэсэгт заасны дагуу ялгагдах өнгө бүхий улсын дугаар авч хэрэглэсэн байна.

1.1.9 Орон нутгийн өмчийн газарт автомашин, мотоцикл, чиргүүл, трактор зэрэг 431 авто тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа бөгөөд үүнээс 308 тээврийн хэрэгсэл улсын дугаар авсан бол 123 тээврийн хэрэгсэл улсын дугаар аваагүй байна. Энэ нь тээврийн хэрэгслийн ашиглалт, хариуцлагын хэрэгжилтэд доголдол үүсгэж, улсын дугааргүй тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой эрсдэлүүдийг бий болгож байна. Иймд орон нутгийн өмчит бүртгэлтэй улсын дугааргүй 123 тээврийн хэрэгсэлд хяналт хэрэгжүүлж, цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр данс бүртгэлээс хасуулах, ашиглах боломжтой тээврийн хэрэгсэлд улсын дугаар авч, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах нь зүйтэй бөгөөд энэ нь хөрөнгийн удирдлагын үр ашиг, хариуцлага, хууль эрх зүйн зохицуулалтыг хангахад чухал ач холбогдолтой.

1.1.10 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална.” гэж заасан байна.

1.1.11 Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 203 дугаар тогтоолын 2 дахь хэсгээр төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишигт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, 2022 оны II улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүргийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан боловч уг зохицуулалтад өөрчлөлт ороогүй байна.

1.1.12 Иймээс одоог хүртэл төрийн албан хаагчийн өрөө тасалгааны жишгийг Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан хэмжүүрээр баримталж байгаа юм. Гэвч бодит нөхцөл байдалтай харьцуулбал Асгат, Баяндэлгэр, Наран, Түвшинширээ, Эрдэнэцагаан сумдын Засаг даргын Тамгын газар болон ИТХ-ын албан хаагчид стандарт жишгээс бага талбайд, зарим тохиолдолд албаны зориулалтгүй орчинд ажил үүргээ

² Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.

гүйцэтгэж байна. Тухайлбал, Түвшинширээ сумын ЗДТГ-ын барилга ашиглах боломжгүй болсноос Соёлын төвийн 4 жижиг өрөөнд нийт 25 албан хаагч ажиллаж байгаа бол, Баяндэлгэр сумын 5 багийн Засаг дарга конторын барилгагүйн улмаас коридорт албан үүргээ гүйцэтгэж байна. Энэ нь төрийн албан хаагчийн ажлын байрны зохистой орчин, үр нөлөөтэй үйл ажиллагааг хангах нөхцөлийг алдагдуулж буйг харуулж байна.

1.1.13 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт (Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар ашиглах боломжгүй болохыг тогтоосон тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гарснаас бусад тохиолдолд захиргааны зориулалтаар барилга шинээр барихыг хориглоно.) гэж хуульчилсан нь шинээр захиргааны барилга барих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлуулахад эрх зүйн тодорхойгүй байдал, хэрэгжилтийн эрсдэл үүсгэж байна. Тухайлбал:

- 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд Мөнххаан сумын Засаг даргын Тамгын газрын барилгыг 1,950.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр шинээр барьж ашиглалтад оруулсан боловч дээрх хуулийн заалтад нийцээгүй гэж үзэх үндэслэлтэй нөхцөл байдал бүрдсэн. Учир нь, барилгын төсөл нь хуулийн 7.1-д заасан "ашиглах боломжгүй" тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэргүйгээр хэрэгжсэн бөгөөд хөрөнгө оруулалтын жагсаалтад "Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Сүхбаатар, Мөнххаан сум/" нэрээр оруулж батлуулсан нь зориулалт, агуулгын зөрүүтэй, төсвийн хөрөнгийн зарцуулалтад ил тод байдал, хуульд нийцэл хангагдаагүй нөхцөл бүрдүүлсэн байна.

1.1.14 Төрийн албан хаагчийн албан өрөөний жишиг талбай, зохион байгуулалт, тоноглолд өөрчлөлт оруулах асуудал шийдэгдээгүй, хуучирсан тогтоол хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа нь сумдын төрийн байгууллагуудын ажлын нөхцөл, орчин шаардлагад нийцэхгүй байгааг харуулж байна. Захиргааны зориулалттай барилга шинээр барих эрх зүйн хязгаарлалт, байгууллагын бодит нөхцөл байдал харгалзахгүй байдал нь төрийн үйлчилгээний хүртээмж, чанарт сөргөөр нөлөөлөх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, эрүүл мэндэд эрсдэл үүсгэх шалтгаан болж байна. Иймд холбогдох эрх зүйн орчныг бодит хэрэгцээ, нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх шаардлагатай байна.

1.1.15 Тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төсвийн байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаанд өмсөх дүрэмт хувцас төсвийн хөрөнгөөр худалдан аваагүй боловч дараах байгууллага албан хаагчдыг ижилсүүлэх зорилгоор төсвийн хөрөнгөөр хувцас худалдан авсан байна. Тухайлбал:

- Асгат сумын ИТХ, ЗДТГ-ын албан хаагчдыг ижил хувцсаар жигдрүүлэх зорилгоор төсвөөс богино хүрэм (куртик) худалдан авахад 2.9 сая;
- Эрдэнэцагаан сумын ЗДТГ 1.2 сая төгрөгийг ажилчдад богино ханцуйтай цамц худалдан авахад тус тус зарцуулсан байна.

1.1.16 Аймгийн ЗДТГ болон Асгат сумын ЗДТГ нь байгууллагаараа жигдрэх, ажилчдаа спортын тэмцээн, уралдаанд оролцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор нийт 4.2 сая төгрөгийн өртгөөр сагсан бөмбөг, волейболын хувцас худалдан авч ашигласан байна. Гэвч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д “төрийн байгууллагын биеийн тамир, спортын арга хэмжээнд төсвийн хөрөнгийг захиран зарцуулахыг хориглоно” гэж заасан тул дээрх зардал нь хуулийн зохицуулалтыг зөрчсөн байна. Иймд байгууллага бүр өөрийн үйл ажиллагааны зардлыг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, байгууллагын имиж, нэг төрх

бүрдүүлэх нэрийн дор хувцас, эд зүйлсийг төсвийн хөрөнгөөр худалдан авахгүй байх, мөн биеийн тамир, спортын арга хэмжээний зардлыг хувийн эх үүсвэр болон бусад зохих хэлбэрээр шийдвэрлэхийг зохион байгуулалтын хувьд анхаарах нь зүйтэй байна.

1.1.17 Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3³-т дотоод албан томилолттой холбоотой зохицуулалтыг хуульчилсан. Гэвч аймгийн төр, захиргааны байгууллагуудаас сумдад томилолтоор ажиллахдаа зарим албан хаагчийн байр, хоолны зардлыг сумдын төрийн байгууллагаар төлүүлэх зөрчил илэрч байна. Түүврээр илэрсэн зөрчлийг дурдвал:

- Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ээлжит цэрэг татлагын комиссын ажлын хэсэг албан томилолтоор ажиллахтай холбоотойгоор 10.9 сая төгрөгийн нөхөн олговор олгосон боловч тухайн сумын Засаг дарга, ЗДТГ-аас цэрэг татлагын үйл ажиллагаанд дахин 3.7 сая төгрөгийг төсвөөс зарцуулсан нь зардлыг давхардуулсан зөрчил юм.
- Хяналт, шинжилгээ-үнэлгээний хэлтсээс хяналт шалгалт хийх, бүсийн сургалт зөвлөгөөн хийсэнтэй холбоотойгоор Эрдэнэцагаан сумын ЗДТГ-аас тус хэлтсийн албан хаагчдын хоол, буудлын зардалд 3.0 сая төгрөг төлсөн;
- Аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор эмч, эмнэлгийн ажилтныг явуулын амбулаториор сумдад ажиллуулахаар томилж 8.3 сая төгрөгийн томилолтын нөхөн олговор олгосон боловч хоолны зардлыг тухайн сумын ЭМТ, ЗДТГ-аар төлүүлсэн байна.
- Аймгийн ИТХ-ын дарга төрийн албан хаагч болон иргэдтэй уулзалт хийхдээ төсвөөс давхар зардал гаргаж байна. Энэ нь зардлын төлөвлөлт, хариуцлагын зааглал тодорхойгүй, дотоод хяналт хангалтгүй байгааг илтгэж байна. Иймд төсвийн зардлыг хууль, тогтоомжийн хүрээнд оновчтой төлөвлөж, ижил үйл ажиллагаанд ижил хугацаанд хоёр эх үүсвэрээс давхар санхүүжилт олгохгүй байх, хяналтын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

1.1.18 Баруун-Урт сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нар нь аймгийн ИТХ-аас зохион байгуулсан төсвийн хариуцлагын чадавхжуулах сургалт болон НҮБ-ын дэмжлэгтэй сургалтад хамрагдахдаа томилолтын нөхөн олговрыг ажлын албаны төсвөөс 1.4 сая төгрөгөөр давхардуулан авсан зөрчил илэрлээ. Энэ нь төсвийн зарцуулалтын давхардал үүсгэж, төсвийн сахилга, хариуцлагыг алдагдуулах эрсдэлтэй тул албан томилолт, зардлын давхардлыг таслан зогсоох, хяналтын механизмыг сайжруулах шаардлагатай байна.

1.1.19 Эдгээр зөрчил нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, давхар зардал нэмэгдэх, хууль зөрчих эрсдэл дагуулахын зэрэгцээ албан хаагчдын ёс зүйн хариуцлага, төрийн байгууллагын ил тод, хариуцлагатай байдлыг сулруулах сөрөг үр дагавартай байна. Иймд дотоод албан томилолтын зардлыг нарийвчлан төлөвлөж, хяналтын тогтолцоог сайжруулах, давхардсан зардал гаргахгүй байх зохицуулалтыг журамлан мөрдүүлэх, томилолтын зардлыг нэгтгэж зохион байгуулах, санхүүгийн хяналт, тайлагнал, ёс зүйн чиглэлээр сургалт сурталчилгаа, хариуцлагын механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага үүссэн байна.

³ Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно

1.1.20 Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3⁴, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3⁵-т заасныг зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ.

1.1.21 УИХ, Засгийн газрын гишүүд, дээд шатны байгууллагын төлөөлөл орон нутагт ажиллах, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулахтай холбоотойгоор хүлээн авалт, хоол, зочид буудлын зардлыг аймгийн Засаг даргын нөөц сан, үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардал болон аймгийн ЗДТГ-ын төсвөөс санхүүжүүлсэн байна. Энэ нь орон нутгийн төсвийн ачааллыг нэмэгдүүлэх, зарцуулалтын үр ашиггүй байдал бий болгох сөрөг үр дагавартай байна. Иймд төрийн өндөр албан тушаалтнуудад хүндэтгэл үзүүлэх, уулзалт зохион байгуулах зэрэг арга хэмжээг төлөвлөхдөө төсвийн үр ашиг, хууль ёсны зарцуулалтыг сайтар тооцож, зохистой байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.1.22 Мөн төрийн албан хаагчдын албан томилолттой холбоотой зардлыг нэг байгууллагаар төлүүлж, давхар томилолтын нөхөн олговор авсан зөрчил илэрч байгаа нь Төрийн албаны болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасан хууль дээдлэх, үнэнч шударга байх, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг зөрчиж, төрийн албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх эрсдэл дагуулж байна. Иймд төсвийн байгууллагуудын зүгээс томилолтын зардлыг нэг эх үүсвэрээс, хууль тогтоомжийн дагуу бодит гүйцэтгэлд тулгуурлан олгох, давхардуулсан зардал гаргахгүй байх хяналтыг төлөвлөлт, гүйцэтгэлийн шатанд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.1.23 Цагдаагийн ерөнхий газраас томилолтын зардлыг албан хаагчид бэлнээр олгохгүйгээр, үйлчилгээ үзүүлсэн байгууллагын нэхэмжлэлд үндэслэн төвлөрсөн санхүүжилтийн дансаар дамжуулан шилжүүлдэг зохицуулалт нь төсвийн үр ашигтай, хяналттай зарцуулалтын сайн туршлага болж байна. Ийм жишгийг нийт төсвийн байгууллагын түвшинд хэвшүүлэх, хууль ёсны зардлын зохицуулалтыг нэг мөр мөрдүүлэх нь төсвийн сахилга бат, ил тод байдлыг хангах чухал нөхцөл болно.

1.1.24 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д хуулиар зөвшөөрөөгүй арга хэмжээнд төсвийн хөрөнгийг зарцуулахыг хориглосон байдаг. Гэсэн хэдий ч орон нутгийн зарим төсвийн байгууллагууд уг хуульд нийцээгүй, хориглосон төрлийн арга хэмжээг зохион байгуулж, төсвийн хөрөнгийг захиран зарцуулсан тохиолдол илэрсэн байна. Энэ нь хуульд заасан төсвийн зориулалт, зарцуулалтын дэг журам, хэмнэлтийн зарчмыг зөрчиж, төсвийн үр ашиггүй, хариуцлагагүй хэрэглээг бий болгох эрсдэлтэй байна. Тухайлбал:

1.1.25 Төрийн албаны тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3⁶ дахь хэсэгт заасныг баримтлалгүй аймгийн Засаг даргын Тамгын газар болон харьяа байгууллагуудын албан хаагчдыг 2023–2024 онд зүүн бүсийн Тамгын газрын спортын арга хэмжээнд оролцуулахтай холбоотойгоор нийт 46.2 сая төгрөгийг төсвөөс зарцуулсан байна. Энэхүү зардал нь төрийн байгууллагын чиг үүрэгт хамааралгүй, хуулиар хориглосон үйл ажиллагаанд зарцуулагдсан нь Төсвийн тухай болон Төрийн албаны тухай хуулийн зарим заалтыг зөрчих, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, төрийн албаны ёс зүй, хариуцлагын зарчим алдагдах нөхцөл бүрдүүлж байна. Иймд

⁴ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

⁵ Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.

⁶ Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг улс төрийн нам, эвсэл, хөдөлгөөний аливаа үйл ажиллагаанд дайчлах, чиг үүрэгт нь үл хамаарах ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.

цаашид төрийн байгууллагын төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг холбогдох хууль, журмын хүрээнд оновчтой төлөвлөж, төрийн чиг үүрэгтэй үл нийцэх зардлыг төсөвт тусгах, санхүүжүүлэхгүй байх хяналтын тогтолцоог сайжруулах шаардлага үүссэн.

1.1.26 Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7-д “Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно” гэж (2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар шинэчлэн тогтоосон.) Харин Сүхбаатар аймгийн Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс тэмдэглэлт өдөртэй холбоотой арга хэмжээнд зориулан дараах байдлаар зардал гаргасан байна. Үүнд:

- Монгол цэргийн өдрийг тохиолдуулан Батлан хамгаалахын сайдтай байгуулсан гэрээг үндэслэн тусгай чиг үүргийн байгууллагын “Марш тактик” тэмцээний шагнал, хүндэтгэл үзүүлэх зардалд 4.5 сая төгрөг;
- “Ардчилал, хүний эрхийн өдөр”-ийг тэмдэглэх хүрээнд Монголын Ардчилсан холбооны гишүүдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд 3.0 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

1.1.27 Дээрх зардлууд нь төсвийн хөрөнгө зарцуулахыг хориглосон зохицуулалтыг зөрчсөн байж болзошгүй нөхцөл байдал үүсгэж байгаа бөгөөд энэ нь төсвийн сахилга, хууль дээдлэх зарчмыг алдагдуулах, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах эрсдэл дагуулж байна.

1.1.28 Дарьганга сумын ЗДТГ-ын албан хаагчид нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн орлого 4.0 сая төгрөгийг (өвс худалдан борлуулсан) Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3.3⁷-т заасныг үндэслэн хамт олны БНХАУ-ын Манжуурын аялалд зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.3⁸-т заасантай зөрчилдөж байна.

1.1.29 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхэд иргэн, хуулийн этгээдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, уралдаан тэмцээн зохион байгуулах, нэрэмжит шагнал урамшуулал олгох зэрэг зохицуулалтгүй байна. Гэтэл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын (ИТХ) дарга гүйцэтгэх засаглалын чиг үүргийг давхардуулан хэрэгжүүлж, 2023-2024 онд батлагдсан ажлын албаны төсвөөс 71.7 сая төгрөгийг дэмжлэг, буцалтгүй тусламж, шагнал урамшуулалд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁹, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2¹⁰, 5.5.5¹¹ дахь заалтыг зөрчсөн. Үүнд:

- Сумын ИТХ-ын ажлын албанаас иргэн, хуулийн этгээдээс ирсэн хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор 2023-2024 онд Баруун-Урт 56.6 сая, Асгат 2.1 сая, Түвшинширээ 1.5 сая, Түмэнцогт 1.6 сая, Уулбаян 4.0 сая, Эрдэнэцагаан 5.9 сая

⁷ нийт ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

⁸ зочин төлөөлөгч хүлээн авах, гадаад томилолтын зардлыг санхүүжүүлэх;

⁹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

¹⁰ Тусгай санг хуулиар байгуулж, татан буулгана.

¹¹ бусад тусгай сангийн үйл ажиллагаатай давхардаагүй байх;

төгрөгийг буцалтгүй тусламж, дэмжлэг, шагнал урамшуулалд тус тус зарцуулжээ;

1.1.30 Энэ нь хуулиар зөвшөөрөөгүй бусад зориулалтаар төсвийн хөрөнгө зарцуулсан бөгөөд үүний улмаас хуулийн зөрчил үүсч, төсвийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулсан байна. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар, тус сангийн хөрөнгийг зөвхөн хуулиар зөвшөөрсөн зориулалтаар зарцуулах ёстой. Иймд энэхүү зөрчлийг арилгах, хуулийг чанд мөрдөж, төсвийн хөрөнгийг зөв ашиглах үүднээс дэмжлэг, буцалтгүй тусламж, шагнал урамшууллыг зөвхөн хуулиар зөвшөөрөгдсөн чиглэлээр зарцуулах албан шаардлага хүргүүлээ

1.1.31 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль 44 дүгээр зүйлийн 44.2¹² дахь хэсэгт, иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлын зарцуулах журмыг Засгийн газар батлах зохицуулалттай байна. Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын хавсралтаар “Төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам” батлагдсан.

1.1.32 Гэвч, ИТХ-ын төлөөлөгчид үйл ажиллагааны зардлыг зориулалт бусаар зарцуулж байгаа тохиолдол илэрч байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан зарцуулалтын чиглэл, зориулалтыг зөрчиж, хууль тогтоомжид нийцэхгүй зарцуулалт болж байна. Үүнд:

- Баруун-Урт сумын ИТХ-ын төлөөлөгчид 2023-2024 оны үйл ажиллагааны зардлын 62.0 сая төгрөгийг журамд заасан зориулалтын дагуу бус, тойргийн зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн халамжийн үйл ажиллагаанд зарцуулсан байна. Тухайлбал, энэ мөнгийг хүнсний болон түлээ нүүрсний тусламж, сургагчдад хичээлийн хэрэглэгдэхүүн болон бага насны хүүхдийг шүдний үзлэгт хамруулах зэрэг үйл ажиллагаанд зарцуулжээ.
- Мөн, Баяндэлгэр, Мөнххаан, Түвшинширээ, Уулбаян, Халзан, Эрдэнэцагаан сумын 2023-2024 оны үйл ажиллагааны зардал болох 121.8 сая төгрөгийг төлөөлөгчийн хувийн дансанд шилжүүлсэн

1.1.33 Засгийн газрын тогтоолоор баталсан журмыг зөрчиж, төлөөлөгчийн хувийн дансаар үйл ажиллагааны зардлыг олгох нь төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах эрсдэл үүсгэж байна. Энэ нь төрийн албаны хариуцлагатай байдлыг сулруулж, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулж, хууль зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлдэг. Тиймээс, төсвийн хөрөнгийг зөвхөн тодорхой, хуульд заасан зориулалтаар зарцуулах шаардлагатай бөгөөд хяналт, зохицуулалтыг хатуу мөрдөх нь зүйтэй юм. Иймд, ИТХ-ын төлөөлөгчийн зардлыг зөвхөн хуулиар заасан чиглэлд, журмын дагуу зарцуулах нь чухал бөгөөд хуулийн дагуу зохих хяналт, тайлагналт ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

1.1.34 МУЗГ-ын 2021 оны 402 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам”-ын 2.3, 2.4 дэх хэсэгт заасан урамшуулал олгох журам нь 2022 оны 404 дугаар тогтоолоор хүчингүй болсон байхад, Асгат, Эрдэнэцагаан сумын ИТХ-ын даргын шийдвэрээр 52.5 сая төгрөгийн төлөөлөгчид урамшуулал олгосон нь хууль зөрчиж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй

¹² Хурлын төсөвт төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлыг тусгана. Зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална.

зарцуулсан байна. Засгийн газрын тогтоолоор батлагдсан журам, хуулийн зохицуулалтыг зөрчин, Төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардлыг зориулалтын дагуу зарцуулах бус, хувийн дансанд шилжүүлж зарцуулсан нь төсвийн хөрөнгийг зориулалт бусаар, үр ашиггүй ашиглах эрсдэл үүсгэсэн байна. Энэ нь төрийн үйл ажиллагаанд шударга, ил тод байдлыг алдагдуулсан үйлдэл болсон гэж үзэж болох бөгөөд уг зөрчил нь төсвийн үр ашиггүй зарцуулалт, хариуцлагагүй байдлыг илтгэж байна.

1.1.35 ИТХ-ын төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг зориулалт бусаар зарцуулсан, урамшуулал хэлбэрээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5¹³, 41 дүгээр зүйлийн 41.2.2¹⁴, 41.2.3¹⁵ дахь, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4¹⁶ дэх, Засгийн газрын 2021 оны 402, 2022 оны 404 дүгээр тогтоолын зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ.

1.1.36 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т зааснаар хэвлэл захиалгын төлбөрийг төсвөөс гаргахыг хориглосон бөгөөд энэ нь төсвийн хөрөнгийг зөв, үр ашигтай зарцуулахад чиглэсэн зохицуулалт юм. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд нь зөвхөн үндсэн үйл ажиллагааны чиг үүрэгтэй холбоотой хэвлэл захиалах эрхтэй байж, бусад төрлийн хэвлэл захиалгыг батлагдсан төсвөөс санхүүжүүлэхгүй байх ёстой. Энэ зохицуулалт нь зардлын хэтрэлтээс зайлсхийж, төсвийн хөрөнгийг хэмнэх, зарцуулалтын хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэж байгаа бөгөөд дээр дурдсан байгууллагууд хэвлэл захиалаагүй байна.

1.1.37 Харин төсвийн байгууллагад эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр үйл ажиллагааны чиг үүрэгт хамааралгүй ном худалдан авах байдал ажиглагдаж байна. Тухайлбал:

- Сүхбаатар аймгийн зохиолчдын эрхлэн гаргасан “Талын түрлэг” номыг аймаг, сумын ЗДТГ-т худалдан борлуулсан бөгөөд уг номыг худалдан авахад төсвөөс 8.5 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Сүхбаатар аймгийн 80 жилийн ойн хүрээнд эрхлэн гаргасан “Сүхбаатар аймгийн түүхэн товчоо” номыг Баруун-Урт сумын ЗДТГ-т 1.2 сая төгрөг;
- Мөнххаан сумын ахмад багшийн эмхэтгэн 100 жилийн түүхт ойн хүрээнд гаргасан номыг нөөц сангийн 14.0 сая төгрөгөөр тус тус худалдан авсан байна.

1.1.38 Харин Эрдэнэцагаан сумын түүхт 100 жилийн ойд зориулан бүтээх номыг “Шинэ Сүхбаатар” төрийн бус байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, Чинберри ХХК-ийн нийгмийн хариуцлагын гэрээний дагуу ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн хөрөнгөнөөс 59.5 сая төгрөгийг зарцуулжээ.

1.1.39 Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 дахь, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 заасантай нийцэхгүй байна.

¹³ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

¹⁴ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

¹⁵ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;

¹⁶ хуулиар зөвшөөрөөгүй бусад.

1.2 Төсвийн хөрөнгийг хууль, журмын хүрээнд зарцуулах шаардлага хангагдаагүй, зарцуулалтын ил тод байдал, санхүүгийн сахилга хариуцлага сул байгаагаас зөрчил, давхардал, зохицуулалтын зөрүү үүссэн байна.

1.2.1 “Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар Баруун-Урт сумын ЗДТГ-ын батлагдсан бүтэц, орон тооны албан тушаалын тодорхойлолтыг түүвэрлэн авч үзэхэд, хэрэгжүүлэх чиг үүрэг нь өөрийн болон бусад байгууллагын чиг үүрэгтэй давхардаж байгаа зөрчлийг илрүүлж, Сүхбаатар аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

1.2.2 Баруун-Урт сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн хүрээнд хорооны хэсгийн ахлагчийг томилох, үйл ажиллагааг нь удирдахаар зааснаас гадна, хуульд тусгагдаагүй багийн хэсгийн ахлагчийг томилон ажиллуулсан бөгөөд төсвөөс 78.2 сая төгрөгийн шагнал, урамшуулал олгожээ. Энэ нь хэсгийн ахлагчийн үүрэг чиглэлийн давхардал үүсгэж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх үүргийг багийн Засаг дарга болон зохион байгуулагч нар гүйцэтгэх учраас төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах эрсдэлтэй болсон байна.

1.2.3 Баруун-Урт сумын 2024 оны ...тогтоолоор 9 дүгээр багийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр боловсруулж, уг хөтөлбөрийн хүрээнд төсвөөс 19.0 сая төгрөгийг зарцуулсан. Уг хөтөлбөр нь Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргасан эрх зүйн актаар зохицуулсан үйл ажиллагааны чиг үүрэгтэй давхардаж байна.

1.2.4 Сумын Засаг дарга нар нөөц сангийн хөрөнгөнөөс нас барсан иргэний ар гэрт буцалтгүй тусламж хэлбэрээр мөнгөн тэтгэмж олгож байгаа нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль болон НДҮЗ-ийн “Тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай” 08 дугаар тогтоолтой давхардсан төсвийн зарцуулалт болж байна. Энэ нь хууль эрх зүйн орчинд давхардал үүсгэж, төрийн сангийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэлтэй бөгөөд тэтгэмжийг зөвхөн зохих төрийн байгууллагаар дамжуулан олгох нь илүү зохистой байх болно.

1.2.5 Тухайлбал: Баруун-Урт сумын Засаг дарга 2023-2024 онд шийдвэр гаргаж дээрх төрлийн тэтгэмжид 4.0 сая төгрөг зарцуулсан байна.

1.2.6 Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6-д шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгохоор тусгажээ.

1.2.7 Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, шагнал урамшуулал, дэмжлэг, буцалтгүй тусламж зэрэг арга хэмжээнд 2024 онд зарцуулсан 186.2 сая төгрөг нь батлагдсан нөөц хөрөнгийн 17.8 хувийг эзэлж байгаа нь төрийн сангийн зохистой зарцуулалтад сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.

1.2.8 Сумын Засаг дарга нарын шийдвэрээр 2023-2024 онд иргэн, аж ахуйн нэгжээс ирсэн хүсэлтүүдийг шийдвэрлэх зорилгоор 119.1 сая төгрөгийг зарцуулсан нь спортын уралдаан тэмцээн, чуулга уулзалт, эмчилгээний зардал зэрэгт зориулсан буцалтгүй тусламжид чиглэжээ.

1.2.9 Журмын 2.1.6-т заасны дагуу иргэд шат, шатны Засаг даргад хүсэлт гаргаж дэмжлэг авах явдал давхардаж байгаа нь төрийн үйлчилгээний тэгш хүртээмжийг хангахгүй бөгөөд зарцуулалт зохисгүй болж, харилцан хамааралтай хүсэлтүүдийг дахин шийдвэрлэх эрсдэл үүсгэж байна. Үүнд:

- *эрүүл мэндийн шалтгааны улмаас гадаадад эмчлүүлэх иргэн аймгийн болон сумын Засаг даргад нэгээс олон удаа хүсэлт гаргаж, мөнгөн дэмжлэг авсан, уран бүтээл туурвисан иргэн хоёр шатны Засаг даргад мөн хүсэлт гаргаж 11.5 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн байна.*

1.2.10 Энэ хүрээнд журмын 2.1.6 дахь заалтыг нарийвчлан зохицуулах хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг судалж, өөрчлөлт оруулах шаардлага үүссэн байна. Энэ нь төсвийн хөрөнгийн хэмнэлт, тэгш боломжийг хангах, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

1.2.11 Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1¹⁷ заасан хөдөлмөрийн харилцаа цуцлагдсан тохиолдолд нэг удаагийн тэтгэмж олгох зохицуулалтыг аймгийн ЗДТГ нь хуульд нийцүүлэн зохицуулах бус, өөрийн дотоод журмаар төрийн албан хаагчид чөлөөлөгдсөн, өөр ажилд шилжин, сэлгэн ажиллаж байгаа тохиолдолд 1-3 сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмж олгохоор тусгасан байна. Үүний дагуу 2023-2024 онд нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 8.5 сая төгрөгийг зарцуулжээ. Энэ нь хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл бөгөөд төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах эрсдэл үүсгэж байна.

1.2.12 Мөн тус газрын хөдөлмөрийн дотоод журамд хууль эрх зүйн актаар тусгайлан зохицуулсан зүйл заалттай давхардуулан шагнал урамшуулал, тэтгэмж олгохоор тусгасан нь хуулийн зөрчилд хүргэдэг. Жишээлбэл, МУЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар төрийн албан хаагчид ажлын гүйцэтгэлээр шагнаж урамшуулах зохицуулалттай байхад, аймгийн ЗДТГ нь дотоод журмаар тэмцээн уралдаанд амжилттай оролцсон албан хаагчдад шагнал олгох заалт оруулсан байна. Мөн Төрийн албаны хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5¹⁸-д заасан тэтгэвэр, тэтгэмжийн зохицуулалтыг зөрчиж, 50-60 нас хүрсэн албан хаагчдад тэтгэмж олгох заалт дотоод журманд тусгасан нь хуульд нийцэхгүй, эрх зүйн давхардуулалт үүсгэж байна.

1.2.13 Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3¹⁹-т заасантай нийцэхгүй байна.

1.2.14 Иймд аймгийн ЗДТГ-ын хөдөлмөрийн дотоод журмыг дахин хэлэлцэж, хууль тогтоомж, эрх зүйн актаар зохицуулагдсан, нийтээр дагаж мөрдөж байгаа тэтгэмж, шагнал урамшуулал олгох чиг үүрэгтэй нийцүүлж, өөрчлөлт оруулах нь зүйтэй. Энэ нь төрийн албан хаагчдын тэтгэмж, шагнал урамшууллын системийг хууль ёсны дагуу зохицуулж, төсвийн хөрөнгийг зөв зохистой зарцуулах, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм

¹⁷ Энэ хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2, 80.1.3-т заасан үндэслэлээр хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран ажил олгогч дараах хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно:

¹⁸ Төрийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг энэ хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар тус тус зохицуулна.

¹⁹ хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;

1.2.15 Аймгийн Засаг даргын нөөц сан, мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас 2024 онд ахмад настан, уулзалт зөвлөгөөн, УИХ-н гишүүн, гадаад, дотоодын зочид төлөөлөгч нарт 67.2 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл гардуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5²⁰-т заасантай нийцэхгүй байна.

1.2.16 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3-т зааснаар төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглосон нь нийгмийн халамжийн шинжтэй үйл ажиллагааг хязгаарлах нөхцөл байдал үүсгэж байна. Тухайлбал, Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1²¹-д төрөөс ахмад настанд хүндэтгэл үзүүлэх талаар тусгасан заалттай зөрчилдөж, төрийн хүндэтгэл үзүүлэх зарим бодлого хэрэгжих боломжгүй болж байна. Мөн НҮБ, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагаас гамшгийн нөхцөлд үзүүлсэн дэмжлэг, хандивыг хүлээн авсан албан хаагч, байгууллагад хүндэтгэл үзүүлэх, төрийн дээд одон медалиар шагнуулсан иргэд, олон улсын тэмцээнд амжилт үзүүлж Монгол Улсын нэрийг дэлхийд таниулсан тамирчдад талархал илэрхийлэх нөхцөл байдал үүсдэг. Гэвч дээрх хориг нь эдгээр үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулах боломжийг хааж, төрийн нэр хүнд, хүндэтгэлийн соёлын илэрхийлэлд сөргөөр нөлөөлж байна. Иймд төрөөс зайлшгүй тохиолдолд хүндэтгэл үзүүлэх, бэлэг дурсгалын зүйл олгох нөхцөлийг тусгай журмаар зохицуулах шаардлагатай бөгөөд эрх бүхий байгууллагаас уг журмыг боловсруулж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн үндсийг бүрдүүлэх нь зүйтэй юм. Энэ нь төсвийн сахилга батыг алдагдуулахгүйгээр хүндэтгэлийн соёлыг хадгалах, хууль хоорондын зөрчлийг арилгах, төрийн албан ёсны үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах ач холбогдолтой.

1.2.17 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх зохицуулалт тусгагдсан. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлант тусгасан байр ашиглалтын зардлыг сүүлийн 5 жилийн байдлаар харьцуулж үзэхэд тогтмол өссөн үзүүлэлттэй гарч байна.

Хүснэгт 1 Байр ашиглалтын зардлын судалгаа 2020-2024 он (сая төгрөгөөр)

Зардлын үзүүлэлт	ОН				
	2020	2021	2022	2023	2024
Гэрэл, цахилгаан	405.4	463.7	619.5	783.5	1,041.5
Түлш, халаалт	4,234.8	4,523.8	4,744.6	5,077.9	7,123.2
Цэвэр, бохир ус	229.7	339.6	444.5	452.9	776.6
ДҮН	4,869.9	5,327.1	5,808.5	6,314.3	8,941.3

1.2.18 Хуульд тогтоомжид заасны дагуу эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, спортын салбарын байр ашиглалтын зардал орон нутгийн чиг үүрэгт хамаарч байна. Судалгаанаас харахад 2024 онд байр ашиглалтын тогтмол зардал өмнөхөөс хамгийн их буюу 41.6 хувиар өссөн байна.

1.2.19 Байр ашиглалтын зардал жил тутамд өссөн үзүүлэлттэй гарч байгаа нь УТХО-аар сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, засаг захиргаа, спорт цогцолбор, соёлын төвийн барилга баригдаж ашиглалтад орсон, эрх бүхий байгууллагын

²⁰ төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;

²¹ 12.1.Жил бүрийн Цагаан сар: билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Ахмадын өдөр: 10 дугаар сарын 1-ний өдрийг тохиолдуулан аж ахуйн нэгж, байгууллага бүр ажиллаж байсан ахмад настанд хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулна.

шийдвэрээр гэрэл цахилгааны тарифт өөрчлөлт орж нэмэгдсэн зэргээс шалтгаалан өссөн байна.

1.2.20 Төрийн байгууллагын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор барилгын гадна талд туузан буюу гоёлын гэрэлтүүлэг хийсэн, хуучин барилга дулааны алдагдал ихтэйгээс хүйтний улиралд цахилгаан халгуур нэмэлтээр ажиллуулж байгаа нь байр ашиглалтын зардал өсөхөд голлон нөлөөлж байна.

1.2.21 Засгийн газрын 2020 оны 144²² дүгээр тогтоолоор төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, дулааны тоолуураар бүрэн хангах ажлыг 2020 оны III улиралд багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч, байгууллагын гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосон. Гэвч Сүхбаатар аймгийн хэмжээнд дээрх тогтоолын хэрэгжилт хангалтгүй, байгууллагуудын дулааны хэрэглээ бодит хэмжүүрээр бус тооцооллоор хийгдсээр байна. Ийм нөхцөл байдал нь төсвийн бодит хэрэгцээг үнэлэх, үр ашигтай зарцуулалтыг төлөвлөх боломжийг хязгаарлаж, төсвийн зардлын илүү төлөлт, эрчим хүчний үр ашиггүй хэрэглээ үүсэх эрсдэлтэй байна. Түүнчлэн хэмнэлтийн бодлого, эрчим хүчний хэрэглээг хянах төрийн зохицуулалтын хэрэгжилт суларч, уялдаа холбоо, хяналтын тогтолцоонд сөргөөр нөлөөлж байна.

1.2.22 Дулааны эрчим хүчний хэрэглээг хэмнэх зорилгоор Баруун-Урт сумын ЗДТГ, Ерөнхий боловсролын хоёрдугаар сургууль гэх мэт байгууллагууд тоолуур тавиулсан боловч Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс тоолууртай үед тооцох тарифт өөрчлөлт оруулснаар, дулааны төлбөр тоолуургүй байх үеийн хэмжээтэй адилхан гарч байна.

1.2.23 Тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх зохицуулалт тусгагджээ.

1.2.24 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд тусгагдсан богино болон урт хугацаат өр төлбөрийг харьцуулж үзэхэд 2023 онд өр төлбөр өмнөх оноос 50.4 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь Азийн хөгжлийн банкны Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн нэмэлт санхүүжилтийн төслийн урт хугацаатай дамжуулан зээлийн гэрээгээр Баруун-Урт сумын төвийн цэвэрлэх байгууламжийг бүтээн байгуулалтын ажилтай холбоотой байна.

Хүснэгт 2. Өр төлбөрийн харьцуулсан судалгаа 2020-2024 он (сая төгрөгөөр)

д/д	Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	951.5	959.9	884.3	663.3	642.2
2	Арилжааны банк	270.0	150.0	-	-	-
3	Ажилчидтай холбогдсон өглөг	111.1	116.9	69.1	84.5	94.4
4	Бараа үйлчилгээний зардлын өглөг	16.0	64.5	-	58.4	3.8
5	Байгууллагад төлөх өглөг /ТӨҮГ/	1,599.1	1,285.9	1,112.4	1,201.5	906.7
6	Хувь хүмүүст төлөх өглөг	113.3	48.1	42.2	32.9	91.6
7	Татварын өглөг /ТӨҮГ/	290.7	190.6	99.1	178.1	115.2

²² Төрийнболон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай

“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн”

8	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	33.6	25.6	24.0	19.8	27.3
9	Дансны өглөг /ТӨҮГ/	279.7	80.1	88.6	93.2	155.5
12	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв урт хугацаат зээл	6,837.8	7,291.6	7,749.9	12,812.3	12,580.3
13	Бусад урт хугацаат өр төлбөр /ТӨҮГ/	-	-	-	2.2	1.5
ДҮН		10,502.8	10,213.3	10,069.6	15,146.2	14,618.6

(Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан)

1.2.25 Богино хугацаат өр төлбөрийн 2024 оны санхүүгийн тайланд тусгагдсан үлдэгдлийн 70.0 хувийг буюу 1,846.9 сая төгрөгийг аймаг, орон нутгийн харьяа аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өр эзэлж байна.

1.2.26 Гэвч дээрх өр төлбөрийн барагдуулах хугацаа, төлөвлөгөө, хуваарь нь тодорхой бус, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор өрийг барагдуулах бодит төлөвлөгөө, арга хэмжээ батлаагүй нь төсвийн сахилга хариуцлагад сөргөөр нөлөөлөх, өр хуримтлагдах, санхүүгийн дарамт нэмэгдэх эрсдэл дагуулж байна.

1.2.27 Иймд аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд нь үүссэн өр төлбөрийг үе шаттайгаар барагдуулах бодит боломжид тулгуурласан төлөвлөгөөг жил бүр боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Бүлэг 2. Төсвийн байгууллагууд цахим дэлгүүр ашиглан худалдан авалт хийх үйл ажиллагаа хангалтгүй, орон нутгийн чиг үүрэг хамаарах төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн байна.

2.1 Орон нутгийн чиг үүрэгт хамаарах төсөл арга хэмжээг УТХО-аар гүйцэтгүүлж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцэхгүй байна.

2.1.1 Хөдөө аж ахуй, хүнс, импортыг орлох хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд эрэмбэлэхээр хуульд заасны дагуу 414 төсөл, арга хэмжээний 16.6 хувь буюу 69 нь хөдөө аж ахуйн салбарт чиглэсэн бөгөөд эдгээрийн дийлэнх нь өвс, тэжээл бэлтгэх, худаг гаргах, агуулах барих зэрэг арга хэмжээ байна.”

2.1.2 Хөдөө аж ахуйн салбарын хэмжээнд төлөвлөсөн 69 төсөл арга хэмжээ нь гүн өрмийн худаг гаргах, нөөцийн өвс тэжээл бэлтгэх, өвс тэжээлийн агуулах барих, хортон мэргэчээс бэлчээр хамгаалах зэрэг арга хэмжээ дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал: Өвс, тэжээлийн нөөц бэлтгэхтэй холбоотой 20 арга хэмжээнд 430.6 сая төгрөгийг төлөвлөж, зарцуулсан байна.

2.1.3 Харин Эрдэнэцагаан сумын 2024 оны ОНХС-ийн төлөвлөгөөний жагсаалтад “наадмын талбайг зүлэгжүүлэлт” нэртэй 19.9 сая төгрөгөөр батлагдсан төсөл арга хэмжээний зардлаар хүндэтгэлийн тулга худалдан авсан. Мөн Төсвийн тухай 42 дугаар зүйлийн 42.7²³ дахь хэсэгт заасныг зөрчсөн байна.

²³ Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.

2.2 ОНХС-ийн төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтыг цахим системд байршуулж хэвшсэн ч төсвийн байгууллагуудын нийт худалдан авсан үндсэн хөрөнгийн зөвхөн 19.0 хувийг цахим дэлгүүрээр дамжуулан авсан байна.

2.2.1 Орон нутгийн хөгжлийн сан, авто замын сан, Сүхбаатар сумын ЭМБС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний төлөвлөгөөг tender.gov.mn цахим системд байршуулж, худалдан авах ажиллагааг цахимаар зарлан сонгон шалгаруулж байна.

2.2.2 Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөгөө, сонгон шалгаруулалтын мэдээллийг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт 3 Цахим худалдан авах ажиллагааны судалгаа

д/д	Үзүүлэлт	Он		
		2022	2023	2024
1	төлөвлөсөн	367	390	414
2	зарласан	143	142	147
3	нээлт хийсэн	143	142	146
4	үр дүн гарсан	139	140	146
5	гэрээ байгуулах эрх олгогдсон	124	125	125
6	гэрээ байгуулсан	98	221	228

(Эх сурвалж: tender.gov.mn цахим сайтын статистик мэдээнээс)

2.2.3 Судалгаанаас харахад төлөвлөсөн арга хэмжээний тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байгаа нь орон нутгийн хөрөнгө оруулалт хариуцсан албан тушаалтан ТБОНӨХБАҮХАТХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.3²⁴, 44.4²⁵ дэх хэсэгт заасныг бүрэн хэрэгжүүлэн ажилласантай холбоотой байна.

2.2.4 Аймгийн ЗДТГ 2024 онд төсвийн хөрөнгөөр 214.6 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 91.9 сая төгрөгийн тавилга, эд хогшил худалдан авсан байна. Хөрөнгийн худалдан авалтаас 109.6 сая төгрөгийн 8 арга хэмжээг ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрийн гэрээгээр, 90.0 сая төгрөгийн 1 арга хэмжээг нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар авсан бол 106.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг иргэн, хуулийн этгээдтэй шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

2.2.5 Сумын ЗДТГ 2023-2024 онд төсвийн хөрөнгөөр нийт 796.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан бөгөөд ихэнх тохиолдолд хувь хүн, хуулийн этгээдтэй шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

2.2.6 Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг зах зээлийн үнэ ханшнаас өндөр үнэлгээтэй гэх үндэслэлээр шууд гэрээгээр худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4²⁶-т заасантай нийцээгүй байна.

2.2.7 Шууд гэрээгээр худалдан авсан арга хэмжээг түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд аймгийн ЗДТГ нь 22.5 сая төгрөгийн худалдан авалтыг хийгээгүй, мөн нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 41.2.2, 41.2.3, Нягтлан

²⁴ Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ.

²⁵ Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ.

²⁶ Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.

бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7²⁷, 20.2.4²⁸, 20.2.5²⁹-д заасан заалтуудыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

2.2.8 АЗДТГ-ын тавилга худалдан авах 24.3 сая төгрөгийн гэрээ, хэлцлийг аудитын хугацаанд бүрэн шалгаж дуусаагүй тул нарийвчилсан горим сорилыг санхүүгийн тайлангийн аудитын завсрын аудитаар авч үзэхээр төлөвлөсөн.

Бүлэг 3. Төсвийг Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн зарцуулаагүйгээс 510.3 сая төгрөгийн хэмнэлтийг орон нутгийн хэмжээнд хийх боломжийг алдаж, үр ашиггүй зарцуулсан нь төсвийн төлөвлөлт, хяналтыг сайжруулах шаардлагатайг илтгэж байна.

3.1 Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлээгүй байна.

3.1.1 Төрийн хэмнэлтийн тухай хуульд хяналтын чиг үүргийг ТАБ, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр зохицуулжээ.

3.1.2 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй байгууллагууд болох Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага болон санхүү, төсвийн асуудал хариуцсан төв байгууллагууд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд шаардлагатай хяналт, хариуцлага тооцох үйл ажиллагааг хангалттай хэмжээнд хэрэгжүүлээгүй байна. Үүнээс үүдэн, санхүүгийн тайлангийн аудитын үеэр 2023 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 277.9 сая төгрөгийн 43 зөрчил илэрч, үүнээс 20.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 218.3 сая төгрөгийн 16 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна. Мөн 39.4 сая төгрөгийн зөрчилд хуулийг дагаж мөрдөх зөвлөмж хүргүүлж, биелэлтийг хангуулсан ч, хэрэгжилтийн чанар нь тодорхой хяналтад байхгүй, шаардлагатай оролцоо дутагдаж байгаа нь хуулийн бүрэн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж байна. Тиймээс, энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд хяналтын байгууллагуудын хариуцлага, оролцоог сайжруулж, хуулийн хэрэгжилтэд илүү анхаарал хандуулах шаардлагатай.

3.1.3 Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх, сайжруулах зорилгоор албаны авто тээврийн хэрэгсэлд GPS суурилуулах зөвлөмж өгснөөр тодорхой үр дүнгээ өгч байна. Авто тээврийн хэрэгсэлд GPS систем байршуулсан байгууллага дараах байдлаар хяналтыг хэрэгжүүлж байна. Тухайлбал: Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ 64-86 СҮА улсын дугаартай авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг өдөрт тутам дараах байдлаар хянаж байна.

Хүснэгт 4. GPS байршлын судалгаа

Бүс	Бүсэд орсон	Бүсээс гарсан	Үргэлжлэх хугацаа
-----	-------------	---------------	-------------------

²⁷ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

²⁸ нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;

²⁹ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;

	Хугацаа	Байршил	Хугацаа	Байршил	
2025 оны 3-р сарын 2 (Ня) - тоо : 3					
Хогийн Нэгдсэн Цэг	9:33	<u>Сүхбаатар</u>	9:47	<u>Сүхбаатар</u>	0:13
Хогийн Нэгдсэн Цэг	11:42	<u>Сүхбаатар</u>	11:53	<u>Сүхбаатар</u>	0:10
Хогийн Нэгдсэн Цэг	14:16	<u>Сүхбаатар</u>	14:28	<u>Сүхбаатар</u>	0:11
2025 оны 3-р сарын 4 (Мя) - тоо : 4					
Хогийн Нэгдсэн Цэг	9:58	<u>Сүхбаатар</u>	10:12	<u>Сүхбаатар</u>	0:14
Хогийн Нэгдсэн Цэг	11:59	<u>Сүхбаатар</u>	12:14	<u>Сүхбаатар</u>	0:15
Хогийн Нэгдсэн Цэг	14:02	<u>Сүхбаатар</u>	14:12	<u>Сүхбаатар</u>	0:10
Хогийн Нэгдсэн Цэг	17:06	<u>Сүхбаатар</u>	17:16	<u>Сүхбаатар</u>	0:10

(Эх сурвалж: Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний бүсийн тайлангаас)

3.2 Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор төсвөөс санхүүгийн дэмжлэг олгож байна.

3.2.1 УИХ, Засгийн газрын гишүүд болон дагалдан явсан ажлын хэсгийнхээ хамт орон нутагт зохион байгуулсан уулзалт, зөвлөгөөн, хүлээн авалт зэрэг арга хэмжээний хоол, хүлээн авалт, зочид буудлын хөлс зэрэгт аймгийн Засаг даргын нөөц сан, үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардал, аймгийн ЗДТГ-ын батлагдсан төсвөөс 204.6 сая төгрөг зарцуулсан байна. Энэ зардлын зарим хэсэг нь сургалт, уулзалт зөвлөгөөнд оролцсон төрийн албан хаагчдыг хооллох, унаа, томилолтын зардалтай давхардсан нь төсвийн үр ашиггүй зарцуулалтад хүргэж байна. Үүнээс үүдэн, томилолт болон зөвлөлдөх арга хэмжээнүүдийн зардлыг нэгтгэн зохицуулах, давхардсан зардлыг бууруулах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

3.2.2 Дээрхээс үзэхэд сургалт, уулзалт зөвлөгөөнд оролцож байгаа төрийн албан хаагчдыг нэгдсэн байдлаар өдөр, орой хооллох нь зардлыг төсөвлөж зарцуулж байгаа нь тухайн албан хаагчид олгосон томилолтын зардал, унаа хоолны хөнгөлөлтийн зардалтай давхцах сөрөг үр дагавар ажиглагдаж байна.

3.2.3 Аймгийн Засаг даргын орлогч, төрийн байгууллагын удирдлагууд Улаанбаатар хотод албан томилолтоор ажиллахдаа албаны авто тээврийн хэрэгсэл ашиглан явсан бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуульд орлогч дарга, агентлагийн албадын дарга авто тээврийн хэрэгсэл ашиглахыг хязгаарласан байдаг. Түүвэрлэн авч үзэхэд, эдгээр албан тушаалтнууд жолоочийн томилолт, шатахууны зардалд 20.8 сая төгрөг зарцуулсан бөгөөд нийтийн тээврийн үйлчилгээг ашигласнаар 18.0 сая төгрөгийг хэмнэх боломжийг алдсан байх жишээтэй байна. Мөн албаны авто тээврийн хэрэгсэл ашиглан зорчих нь техникийн элэгдэл, хорогдол, засвар үйлчилгээний зардал нэмэгдэх эрсдэлтэй бөгөөд энэ нь төсвийн үр ашиггүй зарцуулалтад хүргэх магадлалтай. Тиймээс, энэ асуудлыг зохицуулахын тулд төрийн албан хаагчдын томилолт болон тээврийн хэрэгслийн зардлыг илүү үр ашигтайгаар төлөвлөж, хэмнэлт гаргах боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

3.2.4 Аймаг, сумын ЗДТГ нь албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сургалтын төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор сургалтын үйл ажиллагааг зөвшөөрөлтэй хуулийн этгээдтэй гэрээ байгуулан хэрэгжүүлж, 2023-2024 онд 51.5 сая төгрөг зарцуулсан байна. Гэвч сургалтын үр дүнг, албан хаагчийн ахиц дэвшил, төрийн үйлчилгээг сайжруулах талаар үнэлж тайлагнаагүй бөгөөд сургалтын үйл ажиллагаа, хурал зөвлөгөөн, уулзалт зэрэг үйл ажиллагаанд

зориулан 55.1 сая төгрөгийн цайны материал худалдан авсан нь төсвийн үр ашиг, үр нөлөөний талаар эргэлзээ үүсгэж байна. Иймд төлбөртэй сургалтын үйл ажиллагааг албан хаагчдын хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөж, төсвийн хөрөнгийг үр ашигтай, үр нөлөөтэй байхаар зарцуулах шаардлагатай юм.

3.2.5 Аймгийн Засаг даргын 2021 оны 06-р сарын 10-ны өдрийн А/343 дүгээр захирамжаар батлагдсан “Сүхбаатар аймгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хамгийн өндөр үнэлгээтэй сумын Засаг дарга, агентлаг, албадыг нөөц сангийн хөрөнгөөр урамшуулдаг байна.

3.2.6 Аймгийн Засаг дарга дээрх журмын дагуу урамшуулал шийдвэр гаргахдаа удирдлагыг цалингийн 50-100 хувийн урамшууллыг тухайн байгууллагын цалингийн сангаас гаргахаар шийдвэрлэж байна. Энэ нь тухайн албан тушаалтанд олгож байгаа үр дүнгийн урамшуулалтай давхардаж байгаа бөгөөд чиг үүргээ хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор төсвөөс 11.3 сая төгрөгийн цалингийн зардал нэмэлтээр гарч байна. Иймд А/343 дугаар захирамжаар баталсан журамд өөрчлөлт оруулж урамшууллыг давхардуулан олгож байгаа байдлыг таслан зогсоох нь зүйтэй байна.

3.2.7 Мөн улс, аймаг, сумын аварга малчин шалгаруулж шагнаж урамшуулах үйл ажиллагаанд 2023-2024 онд зарцуулсан хөрөнгийг түүвэрлэн авч үзэхэд 188.9 сая төгрөгийг зарцуулсан байна. Уг үйл ажиллагаатай холбоотойгоор улсын аварга малчнаар шалгарсан өрхөд улс, аймаг, сум, аймгийн аварга малчин өрхөд аймаг, сумын Засаг дарга давхардуулан бэлэг дурсгалын зүйл гардуулж төсвийн хөрөнгийг зохистой бус зарцуулж байна. Мөн шагналыг малчны хотонд гардуулахад Засаг дарга, ИТХ-ын даргаас гадна алба агентлагийн дарга, хэвлэл мэдээллийн ажилтан зэрэг 5-6 хүний бүрэлдэхүүнтэй очиж байгаа нь томилолт, шатахуун зардал давхар гарч байна.

3.2.8 Шагналыг малчны хотонд гардуулахдаа 5–6 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцдог нь томилолт, шатахууны зардлыг нэмэгдүүлж, төсвийн хэмнэлтийн боломжийг алдагдуулж байна. Аймгийн аварга малчин шалгаруулах үйл ажиллагааг сар шинийн баярт зориулсан төрийн шагналын ёслолтой нэгтгэн зохион байгуулах замаар шагналын зардал, томилолт, унааны зардлыг нэгтгэн төлөвлөж, төсвийн зардлыг хэмнэх боломж байсаар байтал ашиглаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

3.2.9 Мөн аймаг, сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс нутгийн зөвлөлийн уулзалт, төрийн хүндэтгэлийн золголтод 80.9 сая, аймаг, сумын болон шилдэг ажилтан шалгаруулах зардалд 115.1 сая төгрөгийг цалингийн сан болон тэтгэмж урамшууллын зардлаас санхүүжүүлэн олгож байна.

3.2.10 Дээрх нөхцөл байдлаас үзэхэд Төрийн хэмнэлтийн тухай хууль орон нутгийн түвшинд үр дүнтэй хэрэгжихгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэд тавих хяналт, байгууллагуудын хариуцлага сул байгаатай холбоотой бөгөөд үүний улмаас төсвийн 510.3 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгох боломж алдагдаж, төсвийн үр ашиг, арвилан хэмнэлтэд сөргөөр нөлөөлсөн байна.

3.2.11 Сүхбаатар аймагт 2023 онд болсон байгалийн гамшгийн улмаас Дорнын чулуулаг ХХК-ийн уурхайн хамгаалалт хангалтгүй байсан нь олон тооны бод мал үхэх нөхцөл болж, иргэдийн хүсэлтийг үндэслэн 10.0 сая төгрөгийн хохирлыг орон

нутгийн төсвөөс гаргасан байна. Гэвч уг хохирол нь тухайн аж ахуйн нэгжийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан болох нь шүүхээр тогтоогдсон тул дээрх төлбөрийг Дорнын чулуулаг ХХК-аар нөхөн төлүүлж, төсвийн хохирлыг барагдуулах шаардлагатай байна.

3.2.12 Сүхбаатар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 19 орон нутгийн өмчит үйлдвэрийн газраас зарим нь дүрэмд заасан чиг үүргийн дагуу өөрийгөө санхүүжүүлэх чадамжгүй байдалд хүрсэн тул байгууллагын үйл ажиллагааг тасалдуулахгүйгээр үргэлжлүүлэх зорилгоор орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлж байна. Үүний шалтгаан нь зах зээлийн орчин, үйлчилгээний өртөг ба орлогын харьцаа алдагдсан, ашиггүй бүтэцтэй байгаатай холбоотой бөгөөд үр дагаварт нь төсвийн дарамт нэмэгдэж, өөрийгөө санхүүжүүлэх зарчим алдагдаж байна. Иймд эдгээр үйлдвэрийн газрын бүтэц, чиг үүрэг, үр ашигт дахин үнэлгээ хийх, зах зээлийн зарчимд нийцүүлэн үр ашигтай зохион байгуулах шаардлага үүсэж байна.

Хүснэгт 5. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт олгосон санхүүгийн дэмжлэгийн судалгаа.

д/д	Хуулийн этгээдийн нэр	Борлуулалтын орлого	Татаас санхүүжилт
1	Сүхбаатар соёл амралтын хүрээлэн	1.1	130.0
2	Сүхбаатар хөгжил ҮТП	43.9	114.0
3	Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт	13.9	347.5
4	Бичигт их өргөө	21.4	50.0
ДҮН		80.2	641.5

(Эх сурвалж: хуулийн этгээдийн 2024 оны санхүүгийн тайлан)

3.2.13 Судалгаанаас харахад орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн удирдлагын зардлыг төсвөөс санхүүгийн дэмжлэгээр шийдвэрлэж байна.

3.2.14 Аймгийн ИТХ болон сумдын ИТХ-ын тогтоолоор шинэ ОНӨААТҮГ-уудыг байгуулж, төсвөөс шууд санхүүгийн дэмжлэг үзүүлэн үйл ажиллагаа явуулж байгаа нь эдгээр үйлдвэрийн газрууд чиг үүргийн дагуу орлого төвлөрүүлж, өөрийгөө санхүүжүүлэх чадваргүй байгааг харуулж байна. Тухайлбал, “Сүхбаатар соёл амралтын хүрээлэн” ОНӨААТҮГ нь үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх барилга байгууламжийг ашиглалтад аваагүй байхад байгуулсан бол “Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги” ОНӨААТҮГ-т 2024 онд 347.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, байнгын төсвийн хамааралтай байдалд орсон байна. Энэ нь төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах тухай Төсвийн тухай хуулийн 6.2.1-д заасан зарчим алдагдахад хүргэж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангагдаагүйг харуулж байна. Цаашид чиг үүргээ биелүүлж чадахгүй, өөрийгөө санхүүжүүлж чадахгүй байгаа үйлдвэрийн газруудыг татан буулгах, үйл ажиллагааг төр-хувийн хэвшлийн түншлэлээр гүйцэтгүүлэх, эсвэл ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагад шилжүүлэх замаар төсвийн зардлын давхардлыг бууруулах шаардлагатай байна. Жишээлбэл, Сүхбаатар аймагт мод үржүүлэг, ногоон байгууламжийн чиглэлээр “Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги”, “Сүхбаатар-ойжуулалт сум дундын ойн анги” зэрэг байгууллагууд байсаар атал 20.0 сая төгрөгийн модны суулгацыг өөр аймгаас худалдан авсан нь нутгийн байгууллагын орлогын боломжийг хязгаарлаж, төрийн худалдан авалтын бодлого уялдаагүй байгааг харуулж байна.

3.2.15 Баруун-Урт сумын ИТХ-ын ээлжит бус долоодугаар хуралдааны 2021 оны 08 сарын 03-ны өдрийн 7/01 тогтоолоор “Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги”

ОНӨААТҮГ-ын байгуулж дүрмийг баталсан. Гэвч тус газарт жил бүр төсвөөс санхүүгийн дэмжлэг олгож байгаа бөгөөд 2024 онд 347.5 сая төгрөгийг олгосон байна. Гэтэл үнсэн үйл ажиллагааны хүрээнд тайлант онд 13.9 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь уг үйлдвэрийн газрын чиг үүргийг нэгтгэх шаардлага байгааг илтгэж байна.

3.2.16 Үйлдвэрийн газрын дүрэмд заасан чиг үүргийн дагуу орлого төвлөрүүлж, байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулж чадахгүй төсвөөс санхүүгийн дэмжлэг авч байгаа газруудыг татан буулгах, чиг үүргийг ижил төстэй үйл ажиллагаа эрхэлж байгаа газарт шилжүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгүүлэх шаардлага үүсжээ.

3.2.17 Үүнээс үзэхэд ашиг, орлого олох чиг үүргээ хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын ажил дуусаагүй байхад урьдчилан үйлдвэрийн газрыг байгуулж, төсвөөс санхүүжилт өгч байгаа нь хууль тогтоомжид заасан төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах үндсэн зарчим алдагдсаныг илтгэж байна. Энэ нь Сүхбаатар аймагт цэцэрлэгжүүлэлт, модны суулгац худалдан борлуулах, ногоон байгууламж арчлан хамгаалах зорилготой “Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги”, “Сүхбаатар-ойжуулалт сум дундын ойн анги” үйл ажиллагаа явуулж байхад төсвийн байгууллагууд “Тэрбум мод” хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хот, Хэнтий аймаг зэргээс 20.0 сая төгрөгийн модны суулгац худалдан авч тарьж байгаагаас харагдаж байна.

3.2.18 Тохижилтын ажлыг хувийн аж ахуйн нэгжээр тендерийн дагуу гүйцэтгүүлж байгаа нь үйлчилгээний чанар, шуурхай байдлыг хангаж байгаа хэдий ч урт хугацааны хувьд төсвөөс гарах зардлыг тогтмол хэмжээнд байлгаж чадахгүй, жил бүр давтагдах санхүүгийн дэмжлэг шаардаж байна. Харин энэхүү үйл ажиллагааг холбогдох чиг үүрэг бүхий ОНӨААТҮГ-аар гүйцэтгүүлснээр байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, ажилтан, техник хэрэгслийн чадавхыг сайжруулах, улмаар байгууллага өөрийн орлогоор үйл ажиллагаагаа санхүүжүүлэх боломж бүрдэх юм.

Түүнчлэн, Эрдэнэцагаан сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 06 дугаар тогтоолоор шинээр байгуулсан “Чоно гол тохижилт” ОНӨҮГ нь 12 орон тоотой, 242.8 сая төгрөгийн цалингийн сантайгаар байгуулагдсан боловч үйл ажиллагаагаа зах зээлийн нөхцөлд орлого төвлөрүүлж, тогтвортой санхүүжүүлэх чадавх сул, төсвөөс хамааралтай байдалд орох өндөр эрсдэлтэй байна. Иймд тухайн үйлчилгээг сумын хэмжээнд тогтмол үйл ажиллагаа явуулж, шаардлагатай туршлага, нөөцтэй ОНӨҮГ-аар хавсран гүйцэтгүүлэх, эсвэл төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шилжүүлэх замаар төсвийн ачааллыг бууруулах боломжтой юм. Энэхүү шийдвэр нь төсвийн хөрөнгийг оновчтой, үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах үндсэн зарчимд нийцнэ.

3.2.19 Эрдэнэцагаан сум ИТХ-ын 2024 оны 12 сарын 29 -ны өдрийн 06 дугаар тогтоолоор “Чоно гол тохижилт” ОНӨҮГ-ыг байгуулж, дүрмийг баталсан байна. Тус газар нь 12 орон тоотойгоор сумын цэвэрлэгээ, үйлчилгээний ажлыг гүйцэтгэхээр байгуулагдсан бөгөөд цалингийн санг 242.8 сая төгрөгөөр баталжээ. Энэ нь үндсэн үйл ажиллагааны орлогоор байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж чадахгүй, төсвөөс санхүүгийн дэмжлэг авах байгууллага болох эрсдэлтэй байна. Иймд тус шийдвэрийг дахин хэлэлцэж тохижилтын үйлчилгээг орон нутагт үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа ОНӨҮГ-аар хавсран гүйцэтгүүлэх нь зүйтэй байна.

3.2.20 Төрийн хэмнэлтийн тухай хууль нь Монгол Улсад төсвийн сахилга бат, үр ашиг, хариуцлагыг дээшлүүлэх, нийтийн хөрөнгийг илүү оновчтой зарцуулах, төрийн үйл ажиллагааны давхардал, үргүй зардлыг бууруулах үндсэн зорилготой хууль юм. Аудитын тайлангаас энэхүү хуулийн хэрэгжилт орон нутгийн түвшинд бүрэн хангагдаагүй, байгууллагуудын зардлын төлөвлөлт, зарцуулалт нь хууль, журамтай нийцэхгүй, хэмнэх боломжийг алдаж байна.

3.2.21 Ялангуяа суудлын автомашины шатахуун, урамшуулал, бэлэг дурсгал, дэмжлэг, баяр тэмдэглэх, хувцас хэрэгсэл зэрэг нь төрийн бодлого, үндсэн чиг үүрэгт шууд хамааралгүй, нийгэм, эдийн засгийн өгөөж багатай зардлууд бөгөөд эдгээр нь төсвийн үр ашиггүй, санхүүгийн сахилгагүй байдлыг улам бүр гүнзгийрүүлж байна. Ийм төрлийн зардлыг төрөөс санхүүжүүлж буй нь хариуцлагын тогтолцоог сулруулж, хууль дээдлэх зарчим, төрийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна.

3.2.22 Иймд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг бүх шатанд тууштай хэрэгжүүлж, хуулийг дагаж мөрдөх хариуцлагын тогтолцоог сайжруулах нь зайлшгүй шаардлагатай. Зөвхөн хууль байгаад зогсохгүй, төрийн хэмнэлтийн зарчим нь санхүүгийн тогтвортой байдал, итгэлцэл, үр ашигт суурилсан засаглалыг бүрдүүлэх үндэс болдог. Төсвийн төлөвлөлт, захиран зарцуулалт нь хууль, төрийн зорилт, иргэдийн эрх ашгийг илэрхийлсэн бодлогоор удирдуулж явагдах ёстой бөгөөд зорилгоо алдагдуулсан, үргүй, давхардсан зардалд төрийн мөнгө үрэх боломжгүй юм. Тийм учраас Төрийн хэмнэлтийн тухай хууль цаашид хэрэгжих нь оновчтой гэж дүгнэж байна.

3.3 Төсвийн байгууллагууд хөрөнгө зарцуулах тушаал шийдвэрийн шилэн дансны цахим системд мэдээлдэггүй нийтлэг зөрчил гаргаж байна.

3.3.1 Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1³⁰-т заасны дагуу Төрийн аудитын байгууллагаас жил бүр хяналт хэрэгжүүлж аудитын үр дүнг УАГ-т хүргүүлсэн.

3.3.2 Сүхбаатар аймгийн төсөв захирагч нарын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 38 зөрчил илрүүлж 5 албан шаардлага, 22 зөвлөмж хүргүүлсэн. Тайлант оны зөрчлийн тоог өмнөх онтой харьцуулахад 68-аар буюу 2.7 дахин буурсан нь аудитаас гарч байгаа үр дүн юм.

3.3.3 Шилэн дансны нэгдсэн сайтад холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулаагүй, авлага, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч,



хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр болон таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг мэдээлээгүй

³⁰ 8.1. Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.

нийтлэг зөрчил илэрлээ. Үүнийг төсөв захирагчаар ангилан хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6 Шилэн дансны зөрчлийн судалгаа / Тоон мэдээллээр/

Төсөв захирагч	Хуулийн заалт	Алдаа зөрчлийн төрөл	Нийт зөрчил
Аймгийн ЗД	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.5	5 сая төгрөгөөр дээш орлого, зарлагыг мэдээлээгүй	2
	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4	Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	2
	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.8	ШДТХ-ийн 6.4.8-д заасан шийдвэрийг мэдээлээгүй	1
	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.4	ШДТХ-ийн 6.4.4-д заасан шийдвэрийг мэдээлээгүй	1
НИЙТ			6
БШУС	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4	Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	17
	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.8	ШДТХ-ийн 6.4.8-д заасан шийдвэрийг мэдээлээгүй	5
НИЙТ			22
Зам тээврийн сайд	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.5	5 сая төгрөгөөр дээш орлого, зарлагыг мэдээлээгүй	1
	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.4	ШДТХ-ийн 6.4.4-д заасан шийдвэрийг мэдээлээгүй	1
НИЙТ			2
Соёлын сайд	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.5	5 сая төгрөгөөр дээш орлого, зарлагыг мэдээлээгүй	1
	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.8	ШДТХ-ийн 6.4.8-д заасан шийдвэрийг мэдээлээгүй	1
НИЙТ			2
Сангийн сайд	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.5	5 сая төгрөгөөр дээш орлого, зарлагыг мэдээлээгүй	1
	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.8	ШДТХ-ийн 6.4.8-д заасан шийдвэрийг мэдээлээгүй	1
НИЙТ			2
ХЗДХС	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.5	5 сая төгрөгөөр дээш орлого, зарлагыг мэдээлээгүй	1
	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4	Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1
	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.8	ШДТХ-ийн 6.4.8-д заасан шийдвэрийг мэдээлээгүй	2
НИЙТ			4
НИЙТ ЗӨРЧИЛ			38

3.3.4 Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “үнэн зөв, бодиттой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх” зарчмыг зарим төсөвт байгууллагууд хангалтгүй мөрдөж байна. Тухайлбал: шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд мэдээллийг байршуулаагүй байх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлэхгүй байх нийтлэг зөрчлүүд байна.

3.3.5 Иймд аймгийн СТСХ, сумын санхүүгийн албаны дарга нар хөрөнгө зарцуулах Засаг даргын захирамжийг шилэн дансны цахим системд мэдээлэх талаар онцгой анхаарч, мэдээллийн ил тод байдлыг иргэд, олон нийтэд цаг алдалгүй хүргэх шаардлагатай байна.

Шалгагдагч байгууллагын саналтай холбоотой тайлбар.



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Сүхбаатар, Баруун-Урт, 7-р Баг, Нутгийн удирдлагын
орлон

Утас: 70510111, Факс: 70510111

Цахим хуудас: admin@sukhbaatar.gov.mn

Цахим хуудас: Sukhbaatar.gov.mn

2025.05.15 № 01/506

танай 2025.05.09 -ны № 419 -т

Тайлбар хүргүүлэх тухай

“Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн” нийцлийн аудитын тайлантай танилцлаа. Аудитын тайланд тусгагдсан асуудлуудыг сумдын төсвийн ерөнхийлөн захирагчид болон төсвийн шууд захирагчдад танилцуулж тайлбар, мэдээллийг авсан гэж үзэж байна. Мөн аудитын явцад манай холбогдох ажилтнууд тайлбар, мэдээллээ өгсөн болно. Иймд дараах саналыг хүргүүлж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль нь зарчмын хувьд зөв бөгөөд төсвийн сахилга батыг сайжруулах, үр ашиггүй зардлыг багасгах зорилготой боловч амьдрал дээр хэрэгжих явцад бодит нөхцөл байдалтай зөрчилдөх нөхцөл цөөнгүй байна. Тухайлбал Орон нутгийн онцлогт тохирохгүй заалтууд байна. Тээвэр, холбоо, шатахууны зардал нь төв сууринаас холдох тусам нэмэгддэг. Гэвч төсөв хэмнэх зорилгоор эдгээр зардлыг огцом хасах нь зарим сумдад ажил гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүсгэдэг.

Албан хаагчдын чадавхижуулах сургалт, арга хэмжээний зардал, шагнал урамшуулал олгох боломж хумигдсанаас ажилтнуудын идэвх, хандлага суларч төрийн үйлчилгээний чанарт нөлөөлөх байдал үүсэх магадлал өндөр байна.

“Хэмнэх зардал” гэсэн заалтад зарим шаардлагатай зардлууд ч багтаж байгаа бөгөөд тухайлбал, бичиг хэрэг, хэвлэл, албан томилолтын зардал бүгд “зайлшгүй биш” гэж хасагдаж байна.

Хуулийн хэрэгжилтийн сөрөг үр дагавар нь төрийн үйлчилгээ доголдож, иргэдэд очих үйлчилгээний хүртээмж буурах, хариуцлага тооцох боломжгүй нөхцөл байдал үүсэж, санхүүгийн сахилга бат улам муудах эрсдэлтэй.

Хэмнэлт хийх, санхүүгийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах нь туйлын чухал хэдий ч үүнийг уян хатан, орон нутгийн нөхцөлд нийцүүлэн хэрэгжүүлэхгүй бол хууль хэрэгжих явцад эсрэг үр дагаварт хүрч болзошгүй. Тиймээс хуулийн

хэрэгжилтийн явц, нөхцөл байдалд бодит мэдээлэлд тулгуурласан хяналт-
шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай гэж үзэж байна



Сүхбаатар аймгийн Засаг даргын Тамгын Газар
Удирдлага
Сүхбаатар аймгийн Засаг дарга
Манлайбаатар Идэрбат
2025-05-15 10:23:19

Шалгагдагч байгууллага тайлангийн төсөлтэй танилцаж, саналын зөрүүтэй тайлбар ирүүлээгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт орон нутгийн түвшинд бүрэн хангагдаагүй бөгөөд зарим төсвийн байгууллагын зүгээс хуулиар хориглосон арга хэмжээнд төсвийн хөрөнгийг зарцуулсан, эрх зүйн зохицуулалтыг үл хэрэгжүүлсэн байдал тогтоогдлоо.
2. Шат шатны удирдлагын хяналт, зохион байгуулалт хангалтгүй, чиг үүргийн давхардал, дотоод журам, шийдвэр нь хууль зөрчсөн, нөөц сан, үйл ажиллагааны зардлыг зориулалтын бусаар зарцуулсан байна. Үүний үр дагаварт, төсвийн 510.3 сая төгрөгийн хэмнэлтийн боломж алдагдаж, нийгэм, эдийн засгийн үр өгөөж буурсан төдийгүй төрийн үйлчилгээний хүртээмж, шударга байдалд сөргөөр нөлөөлсөн байна.
3. Төрийн нэр хүнд, албан хаагчийн ёс зүй, хууль дээдлэх зарчим алдагдах эрсдэл бодитоор илэрч, төрийн албаны үр нөлөө, итгэлцэлд сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдсэн байна. Иймд хуулийн хэрэгжилтийг илүү бодитой болгох, зөрчлийг таслан зогсоох, хариуцлагын тогтолцоог хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.
4. Албан хаагчдын хоол, буудлын зардлыг өөр байгууллагаар төлүүлж, нөхөн олговрыг давхар олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай болон Төрийн албаны ёс зүйн хуулийг зөрчсөн, ашиг сонирхлын зөрчлийг бий болгосон байх эрсдэл үүсжээ.
5. Төлөөлөгчийн үйл ажиллагааны зардлыг зориулалтын бусаар хувийн дансанд шилжүүлэн ашигласан нь хяналтгүй, үр ашиггүй зардлыг бий болгож байна. Засгийн газрын 402, 404 дүгээр тогтоолыг зөрчиж 174.3 сая төгрөгийг журамд үл нийцэх байдлаар зарцуулсан нь төсвийн сахилга, хариуцлагад сөргөөр нөлөөлжээ.
6. Шатахууны зарцуулалт, авто машины хэрэглээнд хяналтгүй байдал хэвээр үргэлжилж, 24.0 сая төгрөгийн хэмнэлтийн нөөц ашиглагдаагүй байна. Төсөвт байгууллагууд хувийн авто машинд шатахуун олгож, зарцуулалт хийсэн нь Засгийн газрын 204 дүгээр тогтоолын хэрэгжилт хангагдаагүй, хэмнэлтэд сөргөөр нөлөөлжээ.
7. Төсвийн хөрөнгийг хуульд заасан хязгаарлалт зөрчин зарцуулсан нь төрийн хэмнэлтийн зарчим бүрэн хэрэгжээгүйг илтгэж байна. Хуулиар хориглосон арга хэмжээ (бэлэг дурсгал, шагнал, спортын хувцас, баяр тэмдэглэх гэх мэт) болон давхардсан чиг үүрэгт зардал гаргасан нь төсвийн сахилга бат алдагдсан, 305.3 сая төгрөгийн хэмнэлтийн боломж алдагдсан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Тухай шатны Засаг даргад:

1. Төсөв төлөвлөх, зарцуулах шатанд төрийн хэмнэлтийн хууль, холбогдох журмуудын заалтыг тусгах зааварчилгааг баталж мөрдүүлэх, мөн бэлэг дурсгал, хүндэтгэлийн арга хэмжээнд зориулсан журам боловсруулах саналыг дээд шатны байгууллагад уламжилж ажиллах;
2. Тэтгэмж, урамшууллын зардлыг төсөвт тусгахдаа хууль заасан чиг үүрэг, эрх хэмжээ, хариуцлагын хүрээнд нарийн тооцоо, үндэслэл гаргах, Тухайлбал хуульд заасан чиг үүргээс давсан, өөр байгууллагын чиг үүрэгтэй давхардсан олголтыг хориглох, хувь хүний хүсэлт, албан бичгээр бус, батлагдсан журам, шалгуурт үндэслэн шийдвэрлэх;
3. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын дүрэм, чиг үүргийг үнэлж, санхүүгийн дэмжлэг олгохоос зайлсхийх, эдгээр газруудыг өөрийн орлогоор санхүүжүүлэх боломжтой болгож, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;
4. Төсөв захирагчид олгож буй хяналт-шинжилгээ, үнэлгээний урамшуулал нь төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулалтай давхардсан зохицуулалт үүсгэж байгаа тул холбогдох журмыг шинэчилж, давхардлыг арилгах;

Аймаг, сумын ЗДТГ, ИТХ-д:

1. Сургалт, уулзалт, зөвлөгөөн зэрэг зардалтай үйл ажиллагааг үр ашигтайгаар төлөвлөж, хөрөнгө зарцуулалтыг илүү сайн удирдах, ялангуяа томилолтын зардлын давхардаж, үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг гаргахгүй байх;
2. Автомашины шатахуун зарцуулалтад дотоод хяналт тогтоож, хяналтын хуудас, шатахуун карт ашиглах, автомашин ашигласан тохиолдолд хязгаар тогтоож, захирамж, гэрээг үндэслэлтэй болгож, бичгээр баримтжуулах;
3. Хувь хүний данс руу шууд шилжүүлдэг санхүүжилтийг бүрэн хязгаарлаж, бичиг баримтаар баталгаажсан, байгууллагын санхүүгийн бүрэлдэхүүнээр олгох, Төрийн нэрийн өмнөөс гарч буй зардлыг хуульд нийцсэн, баримтаар нотлогдох, тайлагнаж болох хэлбэрээр зарцуулах
4. Байгууллагын үйл ажиллагааны болон төрийн албаны чиг үүрэгт хамааралгүй зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх, төсвийг үр ашигтай байхаар төлөвлөж, захиран зарцуулах;
5. Цахим дэлгүүрээс худалдан авалт хийхийг үндсэн зарчим болгож, байгууллагын төлөвлөгөөнд тусгах, зах зээлийн үнэлгээтэй харьцуулан илүү өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг шууд гэрээгээр худалдан авахаас зайлсхийх;
6. Байгууллагын санхүү, бүртгэлийн дансанд бүртгэлтэй боловч улсын дугаар аваагүй тээврийн хэрэгслийн ашиглалтын байдлыг тулган баталгаажуулж, ашиглах боломжтой нэгжийг улсын бүртгэлд бүртгүүлэн ашиглалтад оруулах, ашиглах боломжгүй нэгжийг хууль, журмын дагуу акталж, бүртгэлээс хасах арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

7. Томилолтын зардлыг тухайн байгууллага хариуцаж байгаа тохиолдолд давхар олгохгүй байх;

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газарт:

1. Санхүүгийн тайланд бүртгэгдсэн өр, авлагын хэмжээг бууруулах зорилгоор тухайн байгууллага жил бүр өр төлбөр барагдуулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийн явцыг хянан үнэлж, тайлагнах тогтолцоог бий болгож, өрийн удирдлагыг сайжруулах;

Үндэсний аудитын газраар уламжлуулах санал:

1. Томилолтын давхардсан зардалтай холбоотой санал

Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-д дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулж, зохицуулалтыг нарийвчлан тусгах нь зүйтэй байна. Үүнд:

- Давхардсан томилолтоос шалтгаалсан төсвийн хэтрэлтийг хариуцлагын тогтолцоонд хамруулах.
 - Сургалт, семинар зохион байгуулж буй байгууллага томилолтын зардлыг (байр, хоол, тээвэр, унаа) урьдчилан тооцож, төсөвт тусган, оролцогч байгууллагаас давхар зардал гаргуулахгүй байх болон давхардуулан томилолт олгохгүй байх зохицуулалт оруулах.
2. “Улс төр, тэмдэглэлт баяр, ой, хүндэтгэлтэй холбоотой бэлэг дурсгалын зардлыг тусгай журмаар зөвшөөрсөн нөхцөлд л гаргахыг зөвшөөрнө” гэсэн нөхцөлтэй тайлбар, нэмэлт оруулах

Журмыг шинэчлэх санал: Засгийн газраас бэлэг дурсгал гардуулах, урамшуулал олгох нөхцөлийг “төрийн албаны хүндэтгэл үзүүлэх нийтлэг журам” хэлбэрээр баталж, нэгдсэн зохицуулалт бий болгох.

3. Засаг даргын нөөц сангийн зарцуулалтад тавих хязгаарлалтыг сайжруулах

Сангийн сайдын 61 дүгээр тушаалын **2.1.6 дахь заалтыг шинэчилж**, “нэг удаагийн буцалтгүй тусламж, шагнал урамшууллыг зайлшгүй үндэслэл, нотлох баримтад тулгуурлан олгох бөгөөд хоёр шатны төсөвт байгууллагад давхардал гаргахгүй байх хариуцлагыг аймаг, сумын ИТХ, ЗДТГ хүлээнэ” гэж тодорхой тусгуулах.